



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар АБ1

Амардалай

Мэргэжилтний баг ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 36 дугаар зүйл, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 83 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2022-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3-ийн "Амар тайван, аюулгүйн дүрэм" бүлгийн 4.3.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2022 оны А/95 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдан архинд донтох өвчнийг эдгэрүүлэх болон гэр бүлийн бусад гишүүдийг эдгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж, тодорхой үр дүнд хүрч буй Архичид аминчлахуй(АА) болон Давхар хамаарлын бүлэг (Ал- Анон) , Давхар хамааралтай хүүхдүүдийн бүлэг(Алатөн), Архичдын болон асуудалтай гэр бүлд өссөн насанд хүрсэн хүмүүсийн бүлэг (АСА) нөхөрлөлийн үйл ажиллагааг олон нийтийн сурталчилах зорилгоор сумын хэмжээнд ажиллах чиг үүрэг бүхий "Мэргэжилтний баг"-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2."Мэргэжилтний баг" дээрх нөхөрлөлүүдтэй хамтран ажиллах явцдаа тэдний мөрддөг уламжлал, зарчмыг хүндэтгэн ажилласугай.

3.Мэргэжилтний багийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ажлын явц, үр дүнг тухай бүр мэдээлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сумын Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын нарийн бичгийн дарга (Н.Загдхорол)-д даалгасугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ

4880010074

Сумын Засаг даргын 2022 оны 4 сарын
16 өдрийн 16 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

МЭРГЭЖИЛТНИЙ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн ахлагч: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
Нарийн бичгийн дарга: Нийгмийн бодлогын мэргэжилтэн
Гишүүд:
1-р Багийн Засаг дарга
2-р Багийн Засаг дарга
3-р Багийн Засаг дарга
Цагдаагийн хэсгийн төлөөлөгч
Эрүүл мэндийн төвийн дарга